

АРДЫН ГАР УРЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭН, УРАЛДААН

Уралдааны зорилго:

Евроазийн бүс нутагт суурьшин амьдарч буй бүх Буриад Монголчуудын уран баримал, гар урлал, ардын урлагийн шилдэг уран бүтээлчдийг тодруулах, уран бүтээлийг олон нийтэд түгээх, сурталчлах, уран барималч, ардын гар урлал, дархчууд, уран бүтээлчдийг тодруулах, Бүс нутаг, аймаг, гадаад оронд тархан суурьшсан Буриад дархад, гар урлаачид, уран бүтээлчдийн хамтын ажиллагаа, туршлага солилцоог өргөжүүлэхэд оршино.

Уралдаан болох газар, хугацаа:

2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 28-ны өдрүүдэд Монгол Улс, Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдана.

Уралдааны төрөл:

Уралдаан дараах 5 төрлөөр явагдах ба бүтээлүүдийг Үзэсгэлэн хэлбэрээр дэлгэн үзүүлнэ.

- Модоор урлаж, сийлж хийсэн гар урлалын бүтээлүүд,
- Бүх төрлийн металиар давтаж, цутгаж, сийлж хийсэн уран бүтээл,
- Зөөлөн эдээр хийсэн уран бүтээл /булгиар, арьс, эсгий, адууны дэл, сүүл, бүс даавуу, торго, зээгт наамал гэх мэт/,
- Буриад угсаатны бүлгийн ахуй, өв соёлыг харуулсан уран зураг,
- Буриад угсаатны хэв маяг агуулсан бэлэг дурсгалын зүйлс

Уралдааны үндсэн нөхцөл болон журам:

Уралдаанд:

- Уран барималч ба ардын гар урлаачид,
- Уран баримал, ардын гар урлал бүтээгчдийн нэгдэлүүд оролцоно.
- Тавигдсан уран бүтээлийн уран сайхны чанар, шинэлэг санаа, өвөрмөц байдал нь уралдаанд шалгарах гол нөхцөл болно.
- Гар урлаачдын 2022 оны 07 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Алтаргана наадмаас хойш бүтээсэн, өмнө зохиогдсон "Алтаргана" наадмуудад оролцож байгаагүй бүтээлүүдийг хүлээн авна.
- 1 оролцогч 1 төрөлд 5 хүртэлх бүтээлээр оролцоно.
- Оролцогч бүр бүтээлээ үзэсгэлэнд дэлгэж уран бүтээлийнхээ тухай тайлбарлана. /Хугацаа-5 минут/
- Оролцогчид өөрсдийн бүтээлээ гүйцэтгэсэн технологийн явцаа товчоор харуулах боломжтой бөгөөд уран бүтээлээ дархлах багаж хэрэгсэлтэйгээ оролцож болно.

Уралдаан шүүх шалгуур:

- Гар урлалын бүтээлийн уран сайхны болон гоо зүйн түвшин,
- Урлаачийн мэргэжлийн арга барилын түвшин,
- Бүтээл ур хийц, нарийн хийц шаардсан байдал,
- Гүйцэтгэлийн чанар,
- Бүтээлийн дахин давтагдашгүй шинж чанар

Шүүгчид:

Соёл, урлагийн зүтгэлтнүүд оролцогчдын бүтээлийг шүүнэ. Шүүгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын төлөөлөл 1 хүн, ОХУ-ын субъект тус бүрээс 1 хүн, Монгол улсаас 3 хүн орно.

- Уралдааныг 10 онооны системээр дүгнэнэ.
- Шүүгч нар хөтөлбөрийн дагуу үзэсгэлэнг үзэж онооны хуудсыг бөглөн гарын үсгээ зурна.
- Оролцогчдыг авсан оноогоор нь жагсааж өндөр оноо авсан оролцогчдыг тэмдэглэл үйлдэн шагналд тодорхойлно.
- Оноо тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүгчдийн дарга гаргана. Шүүгчид шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Энэхүү шийдвэр эцсийнх бөгөөд дахин хэлэлцэхгүй.

Уралдааны дүн гаргах:

5 төрөл тус бүрийн шилдэг 3 оролцогчийг /нийт 15 оролцогч/ мөнгөн шагналаар шагнаж, Их наадмын шагналтны Өргөмжлөл гардуулна. Бусад оролцогчдод Их наадамд оролцсон Батламж гардуулна.

Мэдүүлэг өгөх хугацаа, нөхцөл:

Уралдаанд оролцогчид 2024 оны 6 дугаар сарын 10-наас 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.

1. Тогтсон загварын дагуу оролцогчийн мэдүүлгийг бөглөж баталгаажуулан ирүүлнэ. Хугацаа хоцорсон болон дутуу ирүүлсэн тохиолдолд мэдүүлэг хүлээн авахгүй.
2. И-мэйл хаяг: bulgan.soyol@bu.mos.gov.mn /"Ардын гар урлалын үзэсгэлэн" уралдаан гэж тэмдэглэсэн байна/. Шуудангийн хаяг: Соёл урлагийн газар, Тодруулах зүйлийг 70343500, 88779305 утсаар лавлана.

**"Алтаргана-2024" Олон Улсын XV их наадмын "
Ардын гар урлалын үзэсгэлэн" уралдаанд оролцогчдын
МЭДҮҮЛЭГ**

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____
2. Оролцогчийн овог, нэр /эцгийн нэр бүтнээр/ : _____
3. Төрсөн он, сар, өдөр: _____
4. Ажилладаг, сурдаг газар: _____
5. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____
6. Уралдаанд оролцох хөтөлбөр: /бүтээлийн нэр, бүтээлийн тоо, бүтээлийн төрөл, бусад зүйл/ _____
7. Оролцогчийн банкны дансны дугаар _____
8. Оролцогч дараах баримтыг хавсаргана. Үүнд:
 - Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
 - ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар
9. Холбоо барих утас: _____
10. И-мэйл хаяг: _____
11. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____



БУРИАД АРДЫН ДУУ ДУУЛААЧДЫН УРАЛДААН

Уралдааны зорилго

Буриад угсаатны бүлгийн өв соёлыг хамгаалах, хөгжүүлэх, шинэ авъяаслаг дуучдыг нээн илрүүлэх, ардын авьяастнуудын дуулах чадварыг дээшлүүлэх, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Уралдаан болох газар, хугацаа:

2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Монгол Улс, Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдана.

Хамрах хүрээ, Оролцогчид:

Монгол Улсын аймгууд, ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас насны ангилал тус бүрт 1 оролцогч

Уралдаанд оролцох насны ангилал:

- 10-16 нас
- 17-35 нас
- 36-50 нас
- 51 ба түүнээс дээш нас

Уралдааны үндсэн нөхцөл болон журам:

- Уралдаан 2 үе шаттай явагдана.
 - **1 дэх шат:**
 - Оролцогч нь 2 өөр Буриад ардын дуу дуулна. /Нэг дуугаа хөгжмийн зэмсэггүй, нөгөө дуугаа ардын хөгжимтэй дуулна/
 - **2 дахь шат:**
 - Оролцогчид эртний Буриад ардын дуу дуулна. /ардын хөгжимтэй/
- Уралдаанд оролцогчид нэг, хоёрдугаар шатанд давтагдахгүйгээр 3 дуу бэлтгэнэ.
- Микрофонгүй дуулна.
- Төрөл бүрийн фонограмм ашиглахыг зөвшөөрөхгүй.
- Уралдааны гол шалгуур нь орон нутгийнхаа өвөрмөц онцлогийг илэрхийлсэн ардын дууг уг язгуураар нь сэргээн дуулсанд тулгуурлана.
- Мэргэжлийн сургуульд суралцаж байгаа болон мэргэжлийн сургуулийг дуулаачийн мэргэжлээр төгссөн хүнийг уралдаанд оролцуулахгүй.
- Мөн урд жилүүдийн уралдаанд өөр насанд оролцож түрүүлж байсан бол дараагийн насанд оролцож болно.
- Оролцогч хөгжимчнөө бэлтгэж ирнэ.
- Оролцогчдын дарааллыг сугалаагаар шийдвэрлэнэ.

Дүгнэх шалгуур:

- Оролцогчийн дуулах ур чадвар,
- Тайзны соёл, илэрхийлэх ур чадвар,
- Уралдааны журамд тохирох дууг сонгон дуулсан байдал
- Уламжлалт Буриад хувцас

Шүүгчид:

Уралдааныг ардын дууны соёлын зүтгэлтнүүд шүүн тунгаана. Шүүгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын төлөөлөл 1 хүн, ОХУ-ын субъект тус бүрээс 1 хүн, Монгол улсаас 3 хүн орно.

- Уралдааныг 10 онооны системээр дүгнэнэ.
- Шүүгч нар хөтөлбөрийн дагуу үзүүлбэрийг үзэж онооны хуудсыг бөглөн гарын үсгээ зурна.
- Оролцогчдыг авсан оноогоор нь жагсааж өндөр оноо авсан оролцогчдыг тэмдэглэл үйлдэн шагналд тодорхойлно.
- Оноо тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүгчдийн дарга гаргана.
- Шүүгчид шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Энэхүү шийдвэр эцсийнх бөгөөд дахин хэлэлцэхгүй.

Уралдааны дүн гаргах:

Насны ангилал тус бүрийн шилдэг 3 оролцогчийг /нийт 12 хүн/ мөнгөн шагналаар шагнаж, их наадмын шагналтны Өргөмжлөл гардуулна. Бусад оролцогчдод их наадамд оролцсон Батламж гардуулна.

Мэдүүлэг өгөх хугацаа, нөхцөл:

Уралдаанд оролцогчид 2024 оны 6 дугаар сарын 10-наас 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.

1. Тогтсон загварын дагуу оролцогчийн мэдүүлгийг бөглөж баталгаажуулан ирүүлнэ.
2. Хугацаа хоцорсон болон дутуу ирүүлсэн тохиолдолд мэдүүлэг хүлээн авахгүй.
3. И-мэйл хаяг: bulgan.soyol@bu.mos.gov.mn /"Буриад ардын дуу дуулаачдын уралдаан гэж тэмдэглэсэн байна/. Шуудангийн хаяг: Соёл урлагийн газар, Тодруулах зүйлийг 70343500, 88779305 утсаар лавлана.

"Алтаргана-2024" Олон Улсын XV их наадмын
Буриад ардын дуу дуулаачдын уралдаанд оролцогчдын
МЭДҮҮЛЭГ

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____
2. Оролцогчийн овог, нэр /эцэг, эхийн нэр бүтнээр/ : _____
3. Төрсөн он, сар, өдөр: _____
4. Насны ангилал: _____
5. Боловсрол: /боловсролын түвшинг илэрхийлэх диплом, баримт бичгийн хуулбар хавсаргаж ирүүлэх/ _____
6. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____
7. И-мэйл хаяг: _____
8. Холбоо барих утас: _____
9. Оролцогчийн банкны дансны дугаар _____
10. Оролцогч дараах баримтыг хавсаргана. Үүнд:
 - Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
 - ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар
11. Оролцогчийн хөтөлбөр: _____
12. Дууны нэр: /3 дуу/ _____
13. Хөгжимчний овог, нэр: _____
14. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____



ҮЛГЭРЧ, ЕРӨӨЛЧ, МАГТААЛЧДЫН УРАЛДААН

Уралдааны зорилго

Үлгэрч, ерөөлч, магтаалчдын өв уламжлалыг хөгжүүлэх, шилдэг үлгэрч, магтаалчдыг нээн илрүүлэх, тэдний авъяас ур чадварыг дээшлүүлэх, Ардын аман зохиолын баялаг өв санг хойч үедээ таниулах, ардын авъяастнууд, өвлөн уламжлагчдын арга туршлагыг солилцох, дэлгэрүүлэхэд оршино.

Уралдаан болох газар, хугацаа:

2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдана.

Оролцогчид:

Уралдаанд Монгол Улсын аймгууд, ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улс орноос тус бүр 3 хүртэлх оролцогч оролцоно.

Уралдаанд оролцох насны ангилал:

Үлгэр, тууль хайлагч, ерөөлч, магтаалчид, буриадын магтаал шүлэг /магтаал, цол дуудах, буриадын сурын уухай буюу бар барлаач нар/ хэлдэг билэг авъяастнууд 2 насны ангилалаар оролцоно.

- 10-18 нас
- 19 наснаас дээш

Уралдааны үндсэн нөхцөл болон журам:

- Уралдаан нэг үе шаттай зохион байгуулагдана.
- Оролцогч бүр нэг үлгэрийн хэсгээс болон ерөөл, магтаал, туулиас өөрийн сонголтоор уншина.
- Тухайн бүтээлийн найруулгаас хамааран хугацаа 10 хүртэлх минут байна.
- Нутаг нутгийн онцлогийг бүрэн илэрхийлсэн байвал зохино.
- Морин хуур, аман хуур зэрэг ардын хөгжмийн зэмсгийг хэрэглэж болно.
- Хуурцагт шингээсэн бичлэг /фонограмм/ хэрэглэхийг хориглоно.
- Оролцогчдын дарааллыг сугалаагаар шийдвэрлэнэ.

Уралдааныг шүүх шалгуур:

- Өөрийн уран чадварыг бүрэн харуулж, үзэгчдийн сэтгэлийг тухайн үлгэр домгийн орчинд оруулж буй чадвар
- Үг хэллэгийн уран яруу байдал, ярианы болон хөгжмийн уран чадвар
- Оролцогчийн дахин давтагдашгүй байдал
- Жүжиглэлт, уран чадвар
- Уламжлалт буриад хувцас

Шүүгчид:

Соёл, боловсролын зүтгэлтнүүд оролцогчдын үзүүлбэрийг шүүнэ. Шүүгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын төлөөлөл 1 хүн, ОХУ-ын субъект тус бүрээс 1 хүн, Монгол улсаас 3 хүн орно.

- Уралдааныг 10 онооны системээр дүгнэнэ.

- Шүүгч нар хөтөлбөрийн дагуу үзүүлбэрийг үзэж онооны хуудсыг бөглөн гарын үсгээ зурна.
- Оролцогчдыг авсан оноогоор нь жагсааж өндөр оноо авсан оролцогчдыг тэмдэглэл үйлдэн шагналд тодорхойлно.
- Оноо тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүгчдийн дарга гаргана.
- Шүүгчид шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Энэхүү шийдвэр эцсийнх бөгөөд дахин хэлэлцэхгүй.

Уралдааны дүн гаргах:

2 насны ангилал тус бүрийн шилдэг 3 /гурав/ оролцогчийг мөнгөн шагналаар шагнаж, их наадмын шагналтны Өргөмжлөл гардуулна. Бусад оролцогчдод их наадамд оролцсон Батламж гардуулна.

Мэдүүлэг өгөх хугацаа, нөхцөл:

Уралдаанд оролцогчид 2024 оны 6 дугаар сарын 10-наас 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.

1. Тогтсон загварын дагуу оролцогчийн мэдүүлгийг бөглөж баталгаажуулан ирүүлнэ. Хугацаа хоцорсон болон дутуу ирүүлсэн тохиолдолд мэдүүлэг хүлээн авахгүй.
2. И-мэйл хаяг: bulgan.soyol@bu.mos.gov.mn /"Үлгэрч, ерөөлч, магтаалчдын уралдаан гэж тэмдэглэсэн байна/. Шуудангийн хаяг: Соёл урлагийн газар, Тодруулах зүйлийг 70343500, 88779305 утсаар лавлана.
3. Уралдаан болох газраа бүртгүүлэхдээ тоглолтын найруулгаа цаасан дээр болон цахим хэлбэрээр шүүгчдийн бүрэлдэхүүнд 6 ширхэг хувилж өгнө.

“Алтаргана-2024” Олон Улсын XV их наадмын
Үлгэрч, ерөөлч, магтаалчдын уралдаанд оролцогчдын
МЭДҮҮЛЭГ

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____
2. Оролцогчийн овог, нэр /эцгийн нэр бүтнээр/ : _____
3. Төрсөн он, сар, өдөр: _____
4. Ажилладаг, сурдаг газар: _____
5. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____
6. Уралдаанд оролцох хөтөлбөр: _____
7. Оролцогчийн банкны дансны дугаар _____
8. Оролцогч дараах баримтыг хавсаргана. Үүнд:
 - Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
 - ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар
9. Холбоо барих утас: _____
10. И-мэйл хаяг: _____
11. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____



БУРИАД ЯРУУ НАЙРГИЙН УРАЛДААН

Уралдааны зорилго:

Буриад хэлээр бүтээл туурвидаг авьяаслаг яруу найрагчдыг тодруулах, тэдний бүтээлийг хэвлэн нийтлэх, олон нийтэд сурталчлах, алдаршуулахад оршино.

Зохион байгуулах газар, хугацаа:

2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Монгол Улс, Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдана.

Оролцогчид:

Уралдаанд Монгол улсын аймгууд, БНХАУ, ОХУ-ын субъектууд болон бусад гадаад улс орны зохиолчид оролцоно.

Уралдааны үндсэн нөхцөл болон журам:

- Буриад соёл, хэл, уг гарвал, уламжлал, ёс заншил болон буриадуудын өнөө үеийн үнэт зүйл агуулсан шүлгүүдийг хүлээн авна.
- Оролцогчдын дарааллыг сугалаагаар шийдвэрлэнэ.

Уралдаанд оролцох насны ангилал:

- 16-35 нас хүртэл яруу найрагчдын буриад хэл дээр бичсэн 3 хүртэлх шүлэг, найраглал байна.
- 35-аас дээш насны яруу найрагчдын буриад хэл дээр бичсэн 3 хүртэлх шүлэг, найраглал байна.

Уралдааны үе шат:

1-р шат: Гүн ухааны ба уянгын сэдэвтэй шүлэг, найраглалыг наадмын журмын дагуу уншина.

2-р шат: Хоёрдугаар шатанд шалгарсан оролцогчид өөрийн аль нэг бүтээлийг сонгон наадмын журмын дагуу уншина.

3-р шат: Төгсгөлийн шатанд шалгарсан оролцогчид 10 минутад багтаан шүүгчдийн өгсөн сэдвийн дагуу буриад хэл дээр богино хэмжээний шүлэг бичиж уншина.

Дүгнэх шалгуур:

- Яруу найрагчийн ур чадвар
- Яруу найрагчийн уран уншлага, хүний сэтгэлийг хөдөлгөх чадвар
- Шүлгийн дотоод мөн чанар, олон янзын хэмжээс
- Буриад хэлний өв сан баялгийг харуулсан яруу тансаг байдал
- Бүтээлийн давтагдашгүй байдал

Шүүгчид:

Уралдааныг соёлын зүтгэлтнүүд шүүн тунгаана. Шүүгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын төлөөлөл 1 хүн, ОХУ-ын субъект тус бүрээс 1 хүн, Монгол улсаас 3 хүн орно.

- Уралдааныг 10 онооны системээр дүгнэнэ.
- Шүүгч нар хөтөлбөрийн дагуу оролцогчдын бүтээлийг үзэж сонирхон дүгнэлтийн хуудсыг бөглөж гарын үсгээ зурна.

- Оролцогчдыг авсан оноогоор нь жагсааж өндөр оноо авсан оролцогчдыг тэмдэглэл үйлдэн шагналд тодорхойлно.
- Оноо тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүгчдийн дарга гаргана.
- Шүүгчид шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Энэхүү шийдвэр эцсийнх бөгөөд дахин хэлэлцэхгүй.

Уралдааны дүн гаргах:

Хоёр насны ангилал тус бүрийн шилдэг 3 яруу найрагчийг мөнгөн шагналаар шагнаж, Их наадмын шагналтны Өргөмжлөл гардуулна. Бусад оролцогчдод Их наадамд оролцсон Батламж гардуулна.

Мэдүүлэг өгөх хугацаа, нөхцөл:

Уралдаанд оролцогчид 2024 оны 6 дугаар сарын 10-наас 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.

1. Тогтсон загварын дагуу оролцогчийн мэдүүлгийг бөглөж баталгаажуулан ирүүлнэ. Хугацаа хоцорсон болон дутуу ирүүлсэн тохиолдолд мэдүүлэг хүлээн авахгүй.
2. Шүлгийг Word дээр бичиж цахимаар ирүүлнэ.
3. И-мэйл хаяг: Bulgannomiinsan@gmail.com /"Яруу найргийн уралдаан" гэж тэмдэглэсэн байна/. Шуудангийн хаяг: Аймгийн Төв номын сан, Тодруулах зүйлийг 75098999, 96519091, 99755233 утсаар лавлана.

"Алтаргана-2024" Олон Улсын XV их наадмын
Буриад яруу найргийн уралдаанд оролцогчдын
МЭДҮҮЛЭГ

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____
2. Оролцогчийн овог, нэр /эцгийн нэр бүтнээр/ : _____
4. Төрсөн он, сар, өдөр: _____
5. Ажлын газар, сурч буй сургууль: _____
6. Бүтээлийн нэр: _____
7. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____
8. Оролцогчийн банкны дансны дугаар _____
7. Оролцогч дараах баримтыг хавсаргана. Үүнд:
 - Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
 - ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар
8. Холбоо барих утас: _____
9. И-мэйл хаяг: _____
10. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____



“БУРИАДЫН НЭГ ӨДӨР” АРДЫН АМАН ЗОХИОЛЫН ХАМТЛАГИЙН УРАЛДААН

Уралдааны зорилго

Буриад угсаатны бүлгийн хэл аялгуу, аж байдал, ур ухаан, уламжлалт биет болон оюуны соёлыг хадгалах, ёс заншлыг сэргээн хөгжүүлэх, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн уламжлалыг бэхжүүлэхэд оршино.

Уралдаан болох газар, хугацаа:

2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Монгол Улс, Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдана.

Оролцогчид:

Монгол Улсын аймгууд, ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас дээд тал нь 3 хамтлаг оролцоно.

Уралдааны үндсэн нөхцөл болон журам:

- Баг тус бүрийн бүрэлдэхүүн 20 хүнээс хэтрэхгүй /энэ ерөнхий тоонд хүүхэд орохгүй/.
- Уралдаанд оролцогчид нь тухайн газар нутгийн аж амьдралын онцлогт үндэслэн Буриадын амьдралыг харуулна.
- Хамтлагууд ая, шум хариуцах хүнээ тусдаа бэлтгэж ирнэ.
- Хамтлагууд гэр бүлийн уламжлалт баяр, залуучуудын тоглоом, наадам, ард түмний аж амьдралын хэсгүүдээс зохион найруулсан жүжигчилсэн тоглолт бэлтгэж тавина.
- Ардын аман зохиолын төрлүүд /дуу, бүжиг, хөгжмийн зэмсэг, ерөөл, магтаалууд/-с заавал оруулсан байна.
- Хамтлагууд тухайн бүс нутагтаа уламжлагдаж ирсэн өв соёл, тоглоом наадмыг харуулсан байдал, хувцас хэрэглэлийн өвөрмөц онцлог, ардынхаа өв соёлыг хадгалсан байдалд гол анхаарлаа хандуулна.
- Жүжигчилсэн тоглолт 20 хүртэлх минут байна. Хугацаа хэтрүүлбэл үнэлгээ буурна. Хэтэрсэн 1 минут тус бүрт -1 оноо хасагдана.
- Оролцогчдын дарааллыг сугалаагаар шийдвэрлэнэ.

Шалгуур үзүүлэлт:

- Жүжигчилсэн тоглолтын онцлог, өвөрмөц байдал
- Жинхэнэ ардын аман зохиол байх
- Угсаатны хэв шинжийн чиглэл
- Тайзны соёл, гүйцэтгэл
- Буриад уламжлалт хувцас
- Үзүүлбэрт хэрэглэсэн ардын уламжлалт хэрэгсэл

Шүүгчид:

Ардын аман зохиолын салбарын соёлын зүтгэлтнүүд хамтлаг тус бүрийн үзүүлбэрийг шүүнэ. Шүүгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын төлөөлөл 1 хүн, ОХУ-ын субъект тус бүрээс 1 хүн, Монгол улсаас 3 хүн орно.

- Уралдааныг 10 онооны системээр дүгнэнэ.
- Шүүгч нар хөтөлбөрийн дагуу хамтлаг тус бүрийн үзүүлбэрийг үзэж онооны хуудсыг бөглөж гарын үсгээ зурна.

- Хамтлагуудыг авсан оноогоор нь жагсааж өндөр оноо авсан хамтлагийг тэмдэглэл үйлдэн шагналд тодорхойлно.
- Оноо тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүгчдийн дарга гаргана.
- Шүүгчид шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Энэхүү шийдвэр эцсийнх бөгөөд дахин хэлэлцэхгүй.

Уралдааны дүн гаргах:

Шилдэг 5 /тав/ хамтлагийг мөнгөн шагналаар шагнаж, их наадмын шагналтны Өргөмжлөл гардуулна. Оролцсон хамтлагуудад их наадамд оролцсон Батламж гардуулна.

Мэдүүлэг өгөх хугацаа, нөхцөл:

Уралдаанд оролцогчид 2024 оны 6 дугаар сарын 10-наас 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.

1. Тогтсон загварын дагуу оролцогчийн мэдүүлгийг бөглөж баталгаажуулан ирүүлнэ.
2. Хугацаа хоцорсон болон дутуу ирүүлсэн тохиолдолд мэдүүлэг хүлээн авахгүй.
3. И-мэйл хаяг: bulgan.sovool@bu.msc.gov.mn "Буриадын нэг өдөр" уралдаан гэж тэмдэглэсэн байна/ Шуудангийн хаяг: Соёл урлагийн газар, Тодруулах зүйлийг 70343500, 88779305 утсаар лавлана.
4. Уралдаан болох газраа бүртгүүлэхдээ тоглолтын найруулгаа цаасан дээр болон цахим хэлбэрээр шүүгчдийн бүрэлдэхүүнд 6 ширхэг хувилж өгнө.

“Алтаргана-2024” Олон Улсын XV их наадмын
“Буриадын нэг өдөр” уралдаанд оролцох хамтлагийн
МЭДҮҮЛЭГ

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____
2. Хамтлагийн нэр /бүтнээр/: _____
3. Хамтлаг байгуулагдсан он: _____
4. Оролцогчдын тоо (эр/эм): _____
5. Уралдаанд оролцох хөтөлбөр: _____
6. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____
7. Хамтлагийн гишүүдийн нэрс _____
8. Хамтлагийн гишүүдийн дараах баримтыг хавсаргана. Үүнд:
 - Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
 - ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар
9. Хамтлагийн ахлагчийн холбоо барих утас: _____
10. Хамтлагийн ахлагчийн И-мэйл хаяг: _____
11. Хамтлагийн ахлагчийн банкны дансны дугаар _____
12. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____



“ДАНГИНА” ГОО БҮСГҮЙ ШАЛГАРУУДАХ УРАЛДААН

Уралдааны зорилго:

Ардын уламжлалт соёл, уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, бүтээлч санаачилгыг дэмжих, эрүүл амьдрах хэв маягийг сурталчлах, ёс суртахуун, гоо зүйн боловсрол олгоход оршино.

Уралдаан болох газар, хугацаа:

2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Монгол Улс, Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдана.

Оролцогчид:

Уралдаанд Монгол Улсын аймгууд, ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улс орноос тус бүр 3 хүртэл оролцогч оролцоно. /Оролцогчид Буриад хэлээр сайн ярьдаг, 16-22 насны байх/

Уралдааны үндсэн нөхцөл болон журам:

Уралдаан 5 үе шаттай ба дараах хөтөлбөрийн дагуу явагдана. Оролцогчдын дарааллыг сугалаагаар шийдвэрлэнэ.

1. **“Уг гарвал, нутаг усаа магтан дуулья”** – гэсэн уриан дор өөрийнхөө тухай, төрсөн нутаг, уг гарвал удам судрынхаа талаар уран яруу шүлэг, дуу хуур, үлгэр туульсаар чимэглэн сонирхолтой хэлбэрээр илэрхийлж нутагтаа урих.

Шүүх шалгуур үзүүлэлт:

- уламжлалт хувцас
- зохиомж, шинэлэг байдал
- гүйцэтгэл, ур чадвар,
- тайзны соёл,
- сэдвээ илэрхийлэх чадвар,
- Буриад хэлний мэдлэг
- Хугацаа 3 минут

2. **“Сэтгэлийн баяр”**-Үндэсний бүжгийн үзүүлбэр. /Бүжгийн аялгуугаа .mp3 өргөтгөлөөр Wettransfer-т байршуулж татаж авах линкийг bulgan.soyol@bu.moc.gov.mn хаягаар ирүүлнэ/

Шүүх шалгуур үзүүлэлт:

- Зохиомж
- Бүжиглэх ур чадвар
- Уян налархай байдал
- Хувцаслалт
- Илэрхийлэмж
- Хугацаа 3 минут

3. **“Аялга дуу минь”** –Буриад дууны үзүүлбэр. /Дууны аялгуугаа .mp3 өргөтгөлөөр Wettransfer-т байршуулж татаж авах линкийг bulgan.soyol@bu.moc.gov.mn хаягаар ирүүлнэ./

Шүүх шалгуур үзүүлэлт:

- Гүйцэтгэл
- Дуулах ур чадвар
- Тайзны соёл, хувцаслалт
- Илэрхийлэмж

-Хугацаа 4 хүртэлх минут

4. "наргама толон" - Үдшийн гоёлын хувцасны үзүүлбэр /орчин үеийн буриад хувцас, гоёл чимэглэлтэй /

Шүүх шалгуур:

- Үндэсний хувцасны элемент шингээсэн орчин үеийн хувцасны дэлхийн чиг хандлагыг илэрхийлсэн байдал

- Хувцас, гоёл зүүлтний технологийн цэвэр гүйцэтгэл,

- Төгс гоо үзэмжийг бүрдүүлэх

5. "Оюун ухааны сорил" Оролцогч бүр нутаг орныхоо өвөрмөц байдлыг илтгэсэн уламжлалт хэв загварыг хадгалсан хувцастай байна. Буриадын түүх, ёс заншил, уламжлал, үндэсний хоол зэрэг төрөл бүрийн асуултаас билет сугалж хариулна.

Шүүгчид:

Соёлын зүтгэлтнүүд, хувцас загварын агентлагийн мэргэжилтнүүд оролцогчдын үзүүлбэрийг шүүнэ. Шүүгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын төлөөлөл 1 хүн, ОХУ-ын субъект тус бүрээс 1 хүн, Монгол улсаас 3 хүн орно.

- Үзүүлбэрийг 10 онооны системээр дүгнэнэ.
- Шүүгч нар хөтөлбөрийн дагуу үзүүлбэрийг үзэж онооны хуудсыг бөглөн гарын үсгээ зурна.
- Оролцогчдыг авсан оноогоор нь жагсааж өндөр оноо авсан оролцогчдыг тэмдэглэл үйлдэн шагналд тодорхойлно.
- Оноо тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүгчдийн дарга гаргана. Шүүгчид шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Энэхүү шийдвэр эцсийнх бөгөөд дахин хэлэлцэхгүй.

Уралдааны дүн гаргах:

Шилдэг 5 оролцогчийг мөнгөн шагналаар шагнаж, Их наадмын шагналтны Өргөмжлөл гардуулна. Бусад оролцогчдод Их наадамд оролцсон Батламж гардуулна.

Мэдүүлэг өгөх хугацаа, нөхцөл:

Уралдаанд оролцогчид 2024 оны 6 дугаар сарын 10-наас 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.


1. Тогтсон загварын дагуу оролцогчийн мэдүүлгийг бөглөж баталгаажуулан ирүүлнэ. Хугацаа хоцорсон болон дутуу ирүүлсэн тохиолдолд мэдүүлэг хүлээн авахгүй.
2. Дуу, бүжгийн аялгуу болон бусад үзүүлбэрийн ая шумаа mp3 өргөтгөлөөр Wettransfer-т байршуулж татаж авах линкийг bulgan.soyol@bu.moc.gov.mn хаягаар ирүүлнэ.
3. И-мэйл хаяг: bulgan.soyol@bu.moc.gov.mn /"ДАНГИНА ГОО БҮСГҮЙ шалгаруулах уралдаан гэж тэмдэглэсэн байна/. Шуудангийн хаяг: Соёл урлагийн газар, Тодруулах зүйлийг 70343500, 88779305 утсаар лавлана.

"Алтаргана-2024" Олон Улсын XV их наадмын
"ДАНГИНА" гоо бүсгүйн уралдаанд оролцогчдын
МЭДҮҮЛЭГ

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____
2. Оролцогчийн овог, нэр /эцэг, эхийн нэр бүтнээр/ : _____
3. Төрсөн он, сар, өдөр: _____
4. Ажилладаг, сурдаг газар: _____
5. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____

6. Уралдаанд оролцох хөтөлбөр: _____
7. Оролцогчийн банкны дансны дугаар _____
8. Оролцогч дараах баримтыг хавсаргана. Үүнд:
 - Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
 - ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар
9. Холбоо барих утас: _____
10. И-мэйл хаяг: _____
11. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн, төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____

-ооо-





НОМЫН УРАЛДААН

Уралдааны зорилго:

Буриад хэл, соёлоо сахин хамгаалах, хөгжүүлэх, Буриад угсаатнуудын талаарх шилдэг ном, бүтээлийг тодруулах, олон нийтэд түгээх, ном хэвлэл, бүтээлийн хөгжилд хувь нэмрээ оруулахад оршино.

Зохион байгуулах газар, хугацаа:

2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Монгол Улс, Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдана.

Оролцогчид:

Уралдаанд Монгол Улсын аймгууд, БНХАУ, ОХУ-ын субъектууд болон бусад гадаад улс орны зохиолчид оролцоно.

Уралдааны үндсэн нөхцөл болон журам:

- Уралдаанд нэг зохиолч хэд хэдэн бүтээлээр оролцож болно.
- Уралдаанд 2022 оны 8 дугаар сараас 2024 оны 07 дугаар сарын 10 хүртэлх хугацаанд хэвлэгдсэн ном бүтээлээр оролцоно.
- Уралдаанд ирүүлж буй ном бүтээл нь өмнө хэвлэгдсэн байгаад дахин шинээр хэвлэсэн байж болохгүй.

Уралдааны төрлүүд /номинациуд/:

- Буриад хэл дээрх шилдэг ном:
 - Хүүхдийн зохиол,
 - Уран зохиол,
 - Эрдэм шинжилгээний бүтээл, түүхэн болон сэтгүүлчдийн ном бүтээл,
- Гадаад хэл дээр гарсан Буриадууд болон Буриад соёлын тухай шилдэг ном

Шүүгчид:

Уралдаанд оролцогчдын бүтээлийг боловсрол, соёлын салбарын зүтгэлтнүүд шүүн тунгаана. Шүүгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын төлөөлөл 1 хүн, ОХУ-ын субъект тус бүрээс 1 хүн, Монгол улсаас 3 хүн орно.

- Уралдааныг 10 онооны системээр дүгнэнэ. Шүүгч нар хөтөлбөрийн дагуу оролцогчдын бүтээлийг үзэж дүгнэлтийн хуудсыг бөглөж гарын үсгээ зурна.
- Оролцогчдыг авсан оноогоор нь жагсааж өндөр оноо авсан оролцогчдыг тэмдэглэл үйлдэн шагналд тодорхойлно.
- Оноо тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүгчдийн дарга гаргана.
- Шүүгчид шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Энэхүү шийдвэр эцсийнх бөгөөд дахин хэлэлцэхгүй.

Уралдааны дүн гаргах:

“Буриад хэл дээрх шилдэг ном” номинацийн 3 төрлийн тус бүр шилдэг 3 оролцогч, “Гадаад хэл дээр гарсан Буриадууд болон Буриад соёлын тухай шилдэг ном” номинацийн шилдэг 3 оролцогчийг /нийт 12/ мөнгөн шагналаар шагнаж, Их наадмын шагналтны Өргөмжлөл гардуулна. Бусад оролцогчдод Их наадамд оролцсон Батламж гардуулна.

Мэдүүлэг өгөх хугацаа, нөхцөл:


Уралдаанд оролцогчид 2024 оны 6 дугаар сарын 10-наас 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.

1. Тогтсон загварын дагуу оролцогчийн мэдүүлгийг бөглөж баталгаажуулан ирүүлнэ. Хугацаа хоцорсон болон дутуу ирүүлсэн тохиолдолд мэдүүлэг хүлээн авахгүй.
2. Хэвлэгдсэн бүтээл – 2 хувь /эзэнд нь буцааж өгөхгүй/
3. Номыг цахим хэлбэрээр ирүүлнэ. /pdf форматаар/
4. Номын шүүмж
5. Номын тухай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гарсан үнэлэлтүүд /байгаа бол/
6. И-мэйл хаяг: Bulgannomiinsan@gmail.com /"Номын уралдаан" гэж тэмдэглэсэн байна/. Шуудангийн хаяг: Аймгийн Төв номын сан, Тодруулах зүйлийг 75098999, 96519091, 99755233 утсаар лавлана.

"Алтаргана-2024" Олон Улсын XV их наадмын Номын уралдаанд оролцогчдын МЭДҮҮЛЭГ

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____
2. Зохиолчийн овог нэр /бүтнээр/: _____
3. Номын нэр: _____
4. Уралдааны аль төрөлд оролцож байгаа: _____
5. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____
6. Оролцогчийн банкны дансны дугаар _____
7. Оролцогч дараах баримтыг хавсаргана. Үүнд:
 - Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа
 - ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар
8. Холбоо барих утас: _____
9. И-мэйл хаяг: _____
10. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____

-ооо-





ОРЧИН ҮЕИЙН БУРИАД ДУУНЫ УРАЛДААН

Уралдааны зорилго

Орчин үеийн эстрадын дууны төрлийг хөгжүүлэх, оролцогчдын дууны урын санг нэмэгдүүлэх, дуулах чадварыг дээшлүүлэх, шинэ залуу авъяаслаг хөгжмийн зохиолч, дуулаачдыг нээн гаргах, Буриад угсаатны бүлгийн эстрад дууг сурталчлах, Улс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, дуу хөгжим зохиох арга туршлагаас суралцах, уран бүтээлчдийг дэмжихэд оршино.

Уралдаан болох газар, хугацаа:

2024 оны 07 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Монгол Улс, Булган аймгийн Булган суманд зохион байгуулагдана.

Хамрах хүрээ, Оролцогчид:

Монгол Улсын аймгууд, ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улс орноос Орчин үеийн буриад дуу дуулаач төрөлд насны ангилал тус бүрд 1 оролцогч, хөгжмийн зохиолч, яруу найрагч тус бүр 1 оролцогч оролцоно.

Уралдааны үндсэн нөхцөлүүд болон журам: Үүнд:

- Орчин үеийн /эстрад/ буриад дуу дуулаачид:
 - 2 насны ангилалаар явагдах ба оролцогчид 2 дуу бэлтгэн оролцоно.
 - 10-16 нас
 - 17 наснаас дээш
 - Дуулаачийн шалгаруулалтад оролцогчийн дуулах дууны зохиогдсон он дурын байж болно.
 - Мэргэжлийн сургуульд суралцаж байгаа болон мэргэжлийн сургуулийг дуулаачийн мэргэжлээр төгссөн хүнийг уралдаанд оролцуулахгүй.
 - Уралдаанд оролцох дуулаач нь /ганцаар, хоёул, хамтлаг/ байж болно.
 - Оролцогчдын дарааллыг сугалаагаар шийдвэрлэнэ.
- Орчин үеийн буриад дуу зохиогчид:
 - 2 төрлөөр явагдах ба шалгаруулалтад насны ангилал хамаарахгүй
 - Хөгжмийн зохиолч
 - Яруу найрагч
 - Зохиосон дуу нь 2022 оны 07 дугаарын сарын 26-29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Алтаргана наадмаас хойш 2024 оны 07 дугаар сарын 10 хүртэлх хугацаанд зохиогдсон дуу байна
 - Хөгжмийн зохиолчид дууныхаа ая хөгжмийг, үгтэй нь хамт Finale Sibelius гэсэн программаар бичиж ирүүлнэ
 - Дууны үгийг цаасаар болон цахимаар зохион байгуулах хороонд ирүүлнэ.
 - Уралдаанд оролцогчид өөрийн зохиосон, зохиогчийн эрх бүхий дуугаар оролцоно
 - Зохиогчийн эрхтэй холбоотой гарч болзошгүй аливаа эрсдэл, асуудлыг оролцогч талууд бүрэн хариуцна

Орчин үеийн Буриад дуу дуулаачийн уралдааныг шүүх шалгуур:

- Дуулаачийн гүйцэтгэл, ур чадвар,
- Дууны уран бүтээлийн бусдаас ялгарах онцлог, шинэлэг байдал,

- Тайзны соёл
- Дууны уран бүтээлийнхээ утга учрыг бусдад ойлгуулах, илэрхийлэх чадвар

Орчин үеийн Буриад дуу зохиогчдыг шүүх шалгуур:

- Буриад ардын дууны уламжлалт хэв маягийг агуулсан байх,
- Ая дууны хэмнэл, зохицол шинэлэг, өвөрмөц байх,
- Хөгжмийн зохиолчийн бусдаас ялгарах байдлыг харуулсан байх,
- Дууны утга санаа, илэрхийлэмж
- Дууны онцлог талыг хөгжмөөр илэрхийлсэн байдал,
- Дууны үг нь яруу тансаг, утга төгөлдөр байх

Шүүгчид:

Уралдааныг эстрадын дууны соёлын зүтгэлтнүүд шүүн тунгаана. Шүүгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын төлөөлөл 1 хүн, ОХУ-ын субъект тус бүрээс 1 хүн, Монгол улсаас 3 хүн орно.

- Уралдааныг 10 онооны системээр дүгнэнэ.
- Шүүгчид хөтөлбөрийн дагуу үзүүлбэрийг үзэж онооны хуудсыг бөглөн гарын үсгээ зурна.
- Оролцогчдыг авсан оноогоор нь жагсааж өндөр оноо авсан оролцогчдыг тэмдэглэл үйлдэн шагналд тодорхойлно.
- Оноо тэнцсэн тохиолдолд эцсийн шийдвэрийг шүүгчдийн дарга гаргана.
- Шүүгчид шийдвэрээ гарган тэмдэглэл үйлдэнэ. Энэхүү шийдвэр эцсийнх бөгөөд дахин хэлэлцэхгүй.

Уралдааны дүн гаргах:

2 насны ангилал тус бүрийн Орчин үеийн буриад дуу дуулаачийн төрөлд шилдэг 6 оролцогчийг, Орчин үеийн буриад дуу зохиогчийн төрөлд шилдэг хөгжмийн зохиолч 3, яруу найрагч-3 оролцогчийг тус тус шалгаруулж мөнгөн шагналаар шагнаж, их наадмын шагналтны Өргөмжлөл гардуулна. Бусад оролцогчдод их наадамд оролцсон Батламж гардуулна.

Мэдүүлэг өгөх хугацаа, нөхцөл:

Уралдаанд оролцогчид 2024 оны 6 дугаар сарын 10-наас 2024 оны 07 дугаар сарын 10-ны дотор дараах материалыг бүрдүүлэн хүргүүлнэ.

1. Тогтсон загварын дагуу оролцогчийн мэдүүлгийг бөглөж баталгаажуулан ирүүлнэ. Хугацаа хоцорсон болон дутуу ирүүлсэн тохиолдолд мэдүүлэг хүлээн авахгүй.
2. Дуулаачийн уралдаанд оролцогчид дууны аялгуугаа mp3 өргөтгөлөөр Wetansfer-т байршуулж татаж авах линкийг bulgan.soyol@bu.mos.gov.mn хаягаар ирүүлнэ.
3. Хөгжмийн зохиолчид дууныхаа ая хөгжмийг, үгтэй нь хамт Finale Sibelius гэсэн программаар бичиж ирүүлнэ.
4. Дууны үгийг цаасан болон цахим хэлбэрээр зохион байгуулах хороонд ирүүлнэ.
5. И-мэйл хаяг: bulgan.soyol@bu.mos.gov.mn /"Эстрадын дуу дуулаачдын уралдаан гэж тэмдэглэсэн байна/. Шуудангийн хаяг: Соёл урлагийн газар, Тодруулах зүйлийг 70343500, 88779305 утсаар лавлана.

“Алтаргана-2024” Олон Улсын XV их наадмын
Орчин үеийн Буриад дуу дуулаачийн уралдаанд оролцогчийн
МЭДҮҮЛЭГ

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____
2. Оролцогчийн овог, нэр эсвэл хамтлагийн нэр бүтнээр: _____

3. Төрсөн он, сар, өдөр: _____
4. Насны ангилал: _____
5. Боловсрол: /Боловсролын түвшинг илэрхийлэх диплом, баримт бичгийн хуулбар хавсаргаж ирүүлэх: _____
6. Удирдагч багшийн овог, нэр: _____
7. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____
8. Оролцогчийн хөтөлбөр: _____

- 1 дэх дууны нэр _____

Хөгжмийн зохиолч _____

Яруу найрагч _____

- 2 дахь дууны нэр _____

Хөгжмийн зохиолч _____

Яруу найрагч _____

9. Оролцогчийн банкны дансны дугаар _____

10. Оролцогч дараах баримтыг хавсаргана. Үүнд:

- Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа

- ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар

11. Холбоо барих утас: _____

12. И-мэйл хаяг: _____

13. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____

“Алтаргана-2024” Олон Улсын XV их наадмын
Орчин үеийн Буриад дууны зохиогч /хөгжмийн зохиолч, яруу найрагч/ уралдаанд
оролцогчдын
МЭДҮҮЛЭГ

1. Улс, бүс, аймаг орон нутаг _____

2. Оролцогчийн овог, нэр /бүтнээр/: _____

3. Ажилладаг, сурдаг газар: _____

4. Уралдаан тэмцээнд оролцсон байдал, ололт амжилт: _____

5. Дууны нэр _____

6. Зохиосон он, сар: _____

7. Оролцогчийн банкны дансны дугаар _____

8. Оролцогч дараах баримтыг хавсаргана. Үүнд:

- Монгол Улсын аймгуудаас оролцогчид иргэний үнэмлэхний хуулбар эсвэл лавлагаа

- ОХУ-ын субъектууд, БНХАУ болон бусад гадаад улсаас оролцогчид гадаад паспортын хуулбар

9. Холбоо барих утас: _____

10. И-мэйл хаяг: _____

11. Тухайн аймаг, субъектийн Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тамга, гарын үсэг: _____